

БАТЛАВ.
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АМАРСАНАА

БАТЛАВ.
"Ориентплюс" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ц.БОЛДБААТАР

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ
2024 оны 01 сарын 03 өдөр № И-0003/2024 Улаанбаатар хот

Энэхүү гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, 34.2, Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5, Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг үндэслэн нэг талаас 5164753 регистрийн дугаартай "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ, түүнийг төлөөлж Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтсийн дарга Э.Хангал /цаашид "Зохион байгуулагч"/ гэх, нөгөө талаас Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж "Ориентплюс" ХХК, түүнийг төлөөлж Ц.Болдбаатар /цаашид "Зураг төсөл зохиогч"/ гэх, /хамтад нь "талууд" гэх/ нар дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр Зохион байгуулагч нь барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж, Зураг төсөл зохиогч нь магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг хангаж, магадлалын ажлын хөлсийг төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа тэгш эрхийн зарчмыг баримтлах бөгөөд шударгаар хамтран ажиллаж, бие биеийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих үндсэн дээр харилцана.

1.3. Зураг төсөл зохиогч нь дараах ерөнхий мэдээллийг үнэн зөв бөглөнө. Үүнд:

Захиалагч /Хөрөнгө оруулагч/:	Нийслэлийн онцгой байдлын газар
Зураг төслийн гүйцэтгэгч:	"Ориентплюс" ХХК
Барилга байгууламжийн байршил:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12-р хороо
Барилга байгууламжийн нэр:	ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ
Магадлалын ажлын төлбөр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /Гэрээний үнийн дүнгээр/ 2,272,730 /төг/
Архив №:	ОР-05/23

ХОЁР. МАГАДЛАЛЫН АЖЛЫН ТӨЛБӨР

2.1. Зохион байгуулагч холбогдох норм дүрмийн дагуу үнэ бодолт хийж, магадлалын ажлын төлбөрийг тооцно.

2.1.1. Зураг төсөл зохиогч магадлалын ажлын төлбөр 2,272,730 /хоёр сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун гучин / төгрөгийг Зохион байгуулагч байгууллагын Голомт банкны 1175107789 дугаар дансанд энэхүү гэрээний 2.1-д заасан үнэ бодолтыг хийлгэсэн өдөрт багтаан шилжүүлнэ.

2.1.2 Зураг төсөл зохиогч зураг төсөл, хайгуул, судалгааны ажлын үнийн дүнгийн 0.18 хувиар нормчлолын сангийн төлбөрийг тооцож Зохион байгуулагч байгууллагын Худалдаа хөгжлийн банкны 2600078533 дугаар дансанд шилжүүлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажсан өдрөөс хойш хуанлийн 21 өдрийн дотор хүчин төгөлдөр үйлчилнэ.

3.2. Зохион байгуулагч шаардлагатай тохиолдолд гэрээг сунгах болсон шалтгаан нөхцөлийг тодорхой дурдаж, гэрээний хугацааг хуанлийн 21 хүртэл хоногоор нэг удаа сунгах бөгөөд энэ тохиолдолд хугацаа сунгасан нэмэлт гэрээ байгуулна.

3.3. Энэхүү гэрээний 5.1.1-д заасан нөхцөл байдал үүсч, экспертийг дахин томилсон тохиолдолд хугацаа алдсан хоногийг гэрээний нийт хугацаанд нэмж тооцно.

3.4. Талууд гэрээг цуцалснаар, эсвэл гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр, гэрээний хугацаа дууссанаар талуудын гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг дуусгавар болно.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Зохион байгуулагч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

4.1.1. "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ажлын зураг төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас"-ны дагуу Зураг төсөл зохиогчоос магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг гаргуулах;

4.1.2. Эксперт зураг төслийн баримт бичгийг хянаж, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн тохиолдолд зураг төсөл зохиогчоос засвар өөрчлөлтийг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэхийг шаардах;

4.1.3. Магадлал хийлгэхэд шаардагдах зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл хангагдаагүй тохиолдолд магадлал хийлгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;

4.1.4. Зураг төслийн баримт бичгийн иж бүрдэлд тусгагдаагүй боловч магадлал хийх ажлыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай баримт материалыг зураг төсөл зохиогчоос шаардах;

4.1.5. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх экспертийг зураг төслийн цахим системээс санамсаргүй түүврийн аргаар томилох;

4.1.6. Эксперт томилсон томилгооны хуудсыг зураг төсөл зохиогчид хүлээлгэн өгөх;

4.1.7. Томилогдсон эксперттэй холбогдож, зураг төсөлд магадлал хийхээр томилогдсон тухай нэн даруй мэдэгдэх;

4.1.8. Эксперт хүндэтгэн үзэх шалтгааны улмаас магадлал хийх боломжгүй болсон тухайгаа мэдэгдсэн тохиолдолд өөр экспертээр солих;

4.1.9. Экспертийн гаргасан магадлалын дүгнэлтэд техникийн шинжтэй алдаа /үг үсэг, нэршил, байршил... г/м/ гарсан тохиолдолд зураг төсөл зохиогчийн санаачилгаар нягтлан үзэж залруулга хийж ажиллана.

ТАВ. ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зураг төсөл зохиогч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

5.1.1. Эксперт зураг төсөлд магадлал хийхээр томилогдсон өдрөөс хойш ажлын 2 хоногийн хугацаанд утсаа аваагүй, утас нь холбогдох боломжгүй байсан бол дахин эксперт томилуулах хүсэлт гаргах;

5.1.2. "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ажлын зураг төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас"-ны дагуу магадлалын ажилд шаардагдах баримт материалын иж бүрдлийг хангах;

5.1.3. Зураг төслийн баримт бичгийн иж бүрдэлд тусгагдаагүй боловч магадлал хийх ажлыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай баримт материалыг гаргаж өгөх;

5.1.4. Эксперт зураг төслийн баримт бичгийг хянаж, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн тохиолдолд засвар өөрчлөлтийг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх;

5.1.5. Зохион байгуулагчид гаргаж өгсөн баримт материалын үнэн зөвийг хариуцах;

5.1.6. Зураг төслийн цахим мэдээллийн санд нэвтэрч, өөрийн байгуулсан гэрээт ажлын явцад өдөр тутмын хяналт хэрэгжүүлэх;

5.1.7. Гэрээний хугацаанд гэрээний нөхцөл бүрэн биелэгдэх боломжгүй болсон тохиолдолд шалтгаан, тайлбарыг тодорхой дурдаж хугацаа сунгуулах тухай албан бичгээр хандах;

5.1.8. Эксперт зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, эсвэл магадлалын дүгнэлт гаргасны дараа зайлшгүй шалтгааны улмаас өөр экспертээр сольсон тохиолдолд анх үзсэн экспертийн цалинд тооцох хөлсийг зохион байгуулагчид үл маргах журмаар төлнө. /магадлалын ажлын төлбөр дээр нэмж тооцно/

ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

6.1. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр, гэрээний хугацаа дууссанаар талуудын гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг дуусгавар болно. /гэрээ дуусгавар болно/

6.2. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд дараах зарчмыг баримтална.

Үүнд:

6.2.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

6.2.2. Гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцална. Энэ тохиолдолд мөн гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

6.2.2.1. Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд;

6.2.2.2. Гэрээний аль нэг тал итгэл эвдэж, төөрөгдөлд оруулсан нь нөгөө талын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд;

6.3. Зураг төсөл зохиогч энэхүү гэрээний 5.1.4-т заасан үүргээ удаа дараа /2 ба түүнээс дээш/ биелүүлээгүй тохиолдолд зохион байгуулагч байгууллагын санаачилгаар гэрээг цуцална.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2. Гэрээ дуусгавар болох, цуцлахтай холбогдон гарсан үр дагавар /*магадлалын ажлын төлбөр*-ыг талууд дараах байдлаар зохицуулна. Үүнд:

7.2.1. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдээгүй байхад гэрээний хугацаа дуусч /*цаашид сунгаагдахгүй болсон*/, гэрээ дуусгавар болсон тохиолдолд *магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, дүгнэлт гаргасан* экспертүүдийн цалинд тооцох хөлс болон зохион байгуулагч талын хөлсийг буцаан олгохгүй. Харин *магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянаагүй, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгөөгүй, дүгнэлт гаргаагүй* экспертүүдийн цалинд тооцох хөлсийг зураг төсөл зохиогчид буцаан олгоно.

7.2.2. Энэхүү гэрээний 6.2.1-д зааснаар талууд харилцан тохиролцож, гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох тохиолдолд энэхүү гэрээний 7.2.1-д заасан зарчмыг баримтална.

7.2.3. Зураг төсөл зохиогчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг хугацааны өмнө цуцлах тохиолдолд *магадлалын ажлын төлбөрийг буцаан олгохгүй*.

7.2.4. Зохион байгуулагчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг хугацааны өмнө цуцлах тохиолдолд *магадлалын ажлын төлбөрөөс зураг төслийг хянасан, засвар өөрчлөлт оруулахаар зөвлөмж чиглэл өгсөн, дүгнэлт гаргасан* экспертүүдийн цалинд тооцох хөлсийг хэвээр үлдээн, үлдэх төлбөрийг зураг төсөл зохиогчид буцаан олгоно.


НАЙМ. БУСАД

8.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

8.2. Гэрээг хугацааны өмнө цуцлах саналаа нөгөө талдаа ажлын 5 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор хариу ирүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Э.ХАНГАЛ - 2

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Б.УНДРАХ



Захиалагийг төлөөлж:

"ОРИЕНТПЛУС" ХХК-ЫН
ЗАХИГАЛ

Ц.БОЛДБААТАР

Захиалагчийн утас: 8000101
Гүйцэтгэгчийн утас: 99180278

Чингэлтэй дүүрэг, Их тойруу 1,
"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ
Утас: 7011-5255

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТИЙН НЭГТГЭЛ

2024 оны 01 дугаар сарын 29

Дугаар 0116/2024

Улаанбаатар хот

Барилга, байгууламжийн байршил:	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо	
Барилга, байгууламжийн нэр, зориулалт:	"Гал түймэр унтраах, аврах дугаар ангийн барилга"-ын холболтын ажлын зураг төсөл, төсөв	
Зураг төслийн шифр:	OP-05/23	
Хувилбар:	Газар хөдлөлийн 7 балл Гадна агаарын тооцооны хэм: -33.6°C	
Хүчин чадал:	Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 39.65 м х 27.0 м хэмжээтэй, Давхрын тоо: ± 0.00 түвшнээс доош 1 давхар, ± 0.00 түвшнээс дээш 3 давхар, Барилгын ажлын талбай: S=1750.0 м ²	
Захиалагч:	Нийслэлийн онцгой байдлын газар	
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Ориент плюс" ХХК	
Регистрийн дугаар:	5087074	
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2026.04.07	
Ажлын төрөл:	1.2.1 заалтын дагуу	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Нийслэлийн Засаг даргын 2018 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А/816 дугаартай захирамж, Газар эзэмших эрхийн 0000058322 дугаартай гэрчилгээ	
Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Нийслэлийн ерөнхий архитекторын 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан МЗХ2023/24-009 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар	
Зургийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Нийслэлийн онцгой байдлын газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдөр баталсан зураг төсөл боловсруулах даалгавар	
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Нийслэлийн онцгой байдлын газрын дарга болон "Ориент плюс" ХХК-ийн захирал нарын хороонд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан НОБГ/202305004 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ	
Зөвшөөрөлцсөн байгууллагууд:		
Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, Хурандаа		А.Дашням
Нийслэлийн эрүүл мэндийн газрын Чанар, эрүүл мэндийн хяналт зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч		М.Мөнхгэрэл
"Ориент плюс" ХХК-ийн захирал		Ц.Болдбаатар
НОБ газрын ЗУХ-ийн дарга, Онцгой байдлын хурандаа		Б.Баттулга
"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн ТУТ газрын захирал		А.Гантулга

Нийслэлийн Хот Байгуулалт хөгжлийн газрын ИДБТХ-н мэргэжилтэн	Э.Лхагвадорж		
"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн ТУТ газрын ДБТ хэлтсийн мэргэжилтэн	Т.Нармандах		
"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер	Т.Мөнхболд		
Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга	Г.Батзориг		
Нийслэлийн Хот байгуулалтын албаны дарга	Б.Оргил		
Нийслэлийн Онцгой байдлын газрын барилгын зураг төслийн хяналтын байцаагч /ахмад/	Б.Даваасүрэн		
Техникийн нөхцөл олгосон байдал:			
Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо:	Хүчинтэй байх хугацаа:
Дулаан хангамж:	Өөрийн эх үүсвэрээр		
Усан хангамж, ариутгах татуурга:	Өөрийн эх үүсвэрээр		
Цахилгаан хангамж:	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№ 01/01032/23 2023-10-09	1 жил
Холбоо дохиолол:	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	№В-U2023/898 2023-11-06	1 жил
Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл:			
Зураг төслийн бүрдэл:	Зураг төсөл		Магадлал хийсэн экспертний нэр
	Гүйцэтгэсэн байгууллага:	Шалгасан архитектор, инженер	
Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, барилга архитектур	"Ориент плюс" ХХК	Ц.Болдбаатар	И.Гончигбат
Барилга бүтээц:	"Ориент плюс" ХХК	Б.Рэнцэндорж	С.Цэмбэл
Дулаан хангамж:	"Хас проект" ХХК	М.Түвшинжаргал	Б.Цэрэнбалжид
Усан хангамж, ариутгах татуурга:	"Эрдэнийн хүчит суурь" ХХК	Б.Отгонжаргал	Б.Ямпил
Цахилгаан хангамж:	"Анод катод" ХХК	Т.Пүрэвзагд	Ц.Хасбаатар
Холбоо дохиолол:	"Анод катод" ХХК	Т.Пүрэвзагд	Л.Батбаяр
Барилгын төсөв:	"Өрх" ХХК	Ч.Давааням	Ө.Энхтогтох
Инженер геологи:	"Лэнд тест" ХХК /Архив № 23/243/	Ц.Лхагвасүрэн	Дүгнэлт баталгаажсан
Зураг төсөлд магадлал хийсэн экспертүүдээс зөвшөөрсөн 7, татгалзсан эксперт байхгүй байна.			

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Гал түймэр унтраах, аврах дугаар ангийн барилга"-ын холболтын ажлын төсвийн задаргаа

№	Барилга угсралтын ажлын			
	Тодорхойлолт	Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал	Нэгж өртөг /төг/
1	Барилга угсралтын ажил:			
БА,ББ	Барилга нь тэнхлэгээрээ 39.65 м х 27 м хэмжээтэй,	3,189,398,719	1,750.0	1,822,514
ХАС	Давхрын тоо: : Зоорьтой, 3 давхар, Нийт талбайн хэмжээ: 1,750.4 м ² ,	341,051,695	1,750.0	194,887
ЦБУ	Суурь: Төмөр бетон багана, Үндсэн хийц: Цутгамал төмөр бетон арагт бүтээц,	111,349,483	1,750.0	63,628
ДГ-ХТ	Гадна хана: 360 мм-ийн зузаан хөнгөн блок, 150 мм-ийн зузаан	140,553,961	1,750.0	80,317
ХД	хөөсөнцөр хавтан дулаалга, Хучилт: Цутгамал төмөр бетон,	66,493,368	1,750.0	37,996
ДМ	Дээвэр: Хавтгай дээвэртэй.	16,156,335	1,750.0	9,232
	Хэсгийн дүн:	3,865,003,561	1,750.0	2,208,573
2	Гадна цахилгааны шугамын ажил:			
2.1	Гадна цахилгаан /м/: 0.4кВ-ын кабель шугам, АВБ6Шв 1кВ 4х240 мм ²	44,659,673	280	159,499
2.2	Гадна цахилгаан /м/: 10кВ-ын кабель шугам, YJLV23.3х120 мм ²	24,298,031	165	147,261
2.3	Труба хоолой /м/: Замын доогуур труба хоолой сүвлэх	17,536,708	43	407,830
2.4	Гадна цахилгаан /м/: 10кВ-ын агаарын шугам СИП	17,718,227	30	590,608
2.5	Дэд өртөө /ш/: 10/0.4кВ-ын 250кВа чадалтай КТПН	23,916,812	1	23,916,812
2.6	Гадна гэрэлтүүлгийн тэжээл /м/: АВБ6ШВ- 5х10 мм ²	9,552,099	125	76,417
2.7	Гадна гэрэлтүүлэг /ш/: 3.0 м өндөр шонтой	4,582,226	5	916,445
	Хэсгийн дүн:	142,263,776		
3	Гадна холбооны шугамын ажил:			
3.1	Гадна холбоо /м/: Агаарын физик кабель 10 хос	44,049,447	1,900	23,184
3.2	Гадна холбоо /м/: Сувагчлал, сувагчлалын физик кабель 10 хос	11,728,077	122	96,132
	Хэсгийн дүн:	55,777,524		
4	Гадна тохижилтын ажил:			
4.1	Авто зам, зогсоол /м ² /: Асфальтбетон хучилттай	60,984,758	764	79,823
4.2	Явган зам, талбай /м ² /: Өнгөт хавтан хучилттай	12,003,158	190	63,175

4.3	Өндөржилт /м ² : Өндөржилтийн шороо нэмж хасах тэгшилгээ	33,095,058	2,794	11,845
4.4	Ус зайлуулах бетон суваг /м/: 100 мм зузаан элсэн дэвсгэртэй, 100 мм зузаан бетон доторлогоотой	11,275,157	131	86,070
4.5	Ногоон байгууламж /м ² : Зүлэгжүүлэлт	5,698,520	230	24,776
4.6	Гадна хашаа /м ² : Төмөр торон L=221.0 м, H=1.48 м	89,965,034	327	275,122
Хэсгийн дүн:		213,021,685		
5	Гадна цэвэр, бохир усны шугам:			
5.1	Гадна цэвэр усны шугам /м/: Ган хоолой Ф65 мм	1,831,078	5	366,216
5.2	Гадна цэвэр усны дугуй худаг /мм/: Ф2000 мм	5,699,440	1	5,699,440
5.3	Гадна цэвэр усны гүний худаг /м/: Цайрдсан ган хоолой Ф159 мм	47,979,040	100	479,790
5.4	Гадна бохир усны шугам /м/: Бохир усны хуванцар хоолой Ф110 мм, Ф150 мм	22,669,813	41	552,922
Хэсгийн дүн:		78,179,371		
6	Тоног төхөөмж:			
6.1	Халаалтын зуух дулаан механик /ш/: 3 нэр төрөл 8ш			
6.1.1	Халаалтын цахилгаан зуух: N60кВт, 400В, PTE 60	25,846,392	3	8,615,464
6.1.2	Халаалтын сүлжээ насос: UPS40-180F, G-5м ³ /цаг, H-10м /57кг/	6,620,546	2	3,310,273
6.1.3	Нэмэлт усны насос: CR1-48, G-1.0 м ³ /цаг, H-22 м	3,973,710	1	3,973,710
6.1.4	Тэлэлтийн сав: TC-250 л	890,284	1	890,284
6.1.5	Халаалтын нэмэлт усны сав: 0,5м ³	598,936	1	598,936
6.2	Халаалт салхивч /ш/: 3 нэр төрөл 6ш			
6.2.1	Агаар оруулах сэнс: 0 -1.0-2, L800-1020м ³ /цаг N-0.59kw., 18.1 кг 230В RP50-25/22-4, /vo50*25/3R усан агаар халаагчтай/	13,585,481	2	6,792,741
6.2.2	Агаар сорох сэнс: L800-1020м ³ /цаг, N-0.59kw, 18.1 кг 230В RP50-25/22	9,813,336	3	3,271,112
6.2.3	Агаар сорох сэнс: RP60-30/28-4D, L=2000м ³ /цаг, D=230В 1.4кВт	4,584,164	1	4,584,164
6.3	Цэвэр бохир ус /ш/: 6 нэр төрөл 8ш			
6.3.1	Халуун усны эргэлтийн насос: UPS25-120F, G-1.0м ³ /цаг, H-10м, И-0.24 kw /4.6кг/	3,397,810	2	1,698,905

6.3.2	Унд-ахуй, галын өргөлтийн насос: G-14м ³ /цаг, H-34м, N-3kw.220В, CR15-3	10,066,732	2	5,033,366
6.3.3	Цахилгаан эзлэхүүний ус халаагч: V-600l, q-50л/мин, И-12кВт	5,010,330	1	5,010,330
6.3.4	Цэвэр усны тэлэлтийн сав: V-200л	817,778	1	817,778
6.3.5	Нөөц усны сав: V-40 м ³	47,204,219	1	47,204,219
6.3.6	Гүний худгийн насос: G-4л/сек, H-110м, P-7.5kw, SP14A-25	7,256,340	1	7,256,340
6.4	Гадна цахилгаан, программ хангамж: /ш/: 3 нэр төрөл 3ш			
6.4.1	Программ хангамж бүхий компьютер	6,680,440	1	6,680,440
6.4.2	Дизель генератор 220Ква /FG WILSON/	97,903,000	1	97,903,000
6.4.3	10/04кВ 250 кВа КТПН дэд өртөө	28,219,100	1	28,219,100
	Хэсгийн дүн:	272,468,599		
7	Зураг төслийн үнэ:			
ЗТҮ	Зураг төслийн үнэ	50,000,000		
	Хэсгийн дүн:	50,000,000		
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо				
БУ	Барилга угсралт /үндсэн/:			3,865,003,561
ГЦ	Гадна цахилгаан хангамж:			142,263,776
ГХ	Гадна холбоо:			55,777,524
ГТ	Гадна тохижилт, зам талбай:			213,021,685
ЦБУ	Гадна цэвэр, бохир усны шугам:			78,179,371
ТТ	Тоног төхөөмж:			272,468,599
ЗТҮ	Зураг төслийн үнэ:			50,000,000
	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:			4,676,714,516

Төсөв: Эксперт нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Гал түймэр унтраах, аврах дугаар ангийн барилга"-ын холболтын ажлын нийт төсөвт өртгийг **4,676,714,516.0** /Дөрвөн тэрбум зурган зуун далан зургаан сая долоон зуун арван дөрвөн мянга таван зуун арван зургаан/ төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.", 39.5-д "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Гал түймэр унтраах, аврах дугаар ангийн барилгын холболт"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилгын тухай хууль"-ийн 34.1.4, 34.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 51 дүгээр тогтоол, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэн бүртгэлийн дугаар олгов.

Дүгнэлтийн нэгтгэл нь экспертүүдийн **12** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Д.АЛТАНХУЯГ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.УНДРАХ




Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /**Барилга архитектур:**/
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ

2024 оны 01 сарын 05 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12-р хороо
3	Зураг төслийн байгууллага	"Ориентплюс" ХХК
4	Зургийн шифр	
5	Хуудасны тоо	
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	АТД-МЗХ 2023/24-009 тоот, 2023.07.08 батлагдсан эскиз зурагтай, БЦУЕӨ-г ТБ-т тусгасан.
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Нэг маягийн холболтын зургийг НОБГ, НЭМГ-тай зөвшөлцсөн, зураг төсөл боловсруулсан "ОРИЕНТПЛЮС" ХХК, захиалагч НОБГ батласан.
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	Ажлын зургийг/ холболт/ АТД-т тусгасан болон холбогдох норм дүрмийн дагуу боловсруулсан.
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Зураг төслийн шийдлээр ХАБ, ТТАА, ЭАНормын шаардлагуудыг хангуулах боломжтой.

Д/д	Утга	Тайлбар
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Гүйцэтгэгч байгууллага БҮТЗБ-ийн зураглал боловсруулахдаа ХАБ, ТТАА-ны нөхцөл шаардлагыг тусгаж захиалагчаар батлуулан мөрдөж ажиллана.
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	Байрших нутаг дэвсгэр, эдэлбэр газрын нөхцөлтэй уялдуулан холболтын зураг төслөөр гүйцэтгэл хийх боломжтой хувилбар сонгосон.
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	АТД-т тусгасан шаардлагын агуулгаар төлөвлөлтөнд тусгах
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	ЧД-ийн захын хорооны хүн амын амь нас, эд хөрөнгө, эрүүл мэндийг галын болзошгүй аюулаас хамгаалах зориулалтаар хүртээмжийг ойртуулсан гал түймэр унтраах ангийн барилгын төсөл тул нийгэм эдийн засгийн ач холбогдолтой
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	-Өндөржилттэй уялдуулж инженерийн бэлтгэл ажлын элементүүд болох үерийн далан, суваг шуудууны байршил төлөвлөлтийг тодотгох -Экспертүүд болон мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж шаадлагын дагуу зураг төслийн сайжруулж БУА-г гүйцэтгэх боломтой.
Дүгнэлт бичсэн Эксперт № 1-27		 <p>И.Гончигбат /...../</p> <p>2024 оны 01 сарын 05 өдөр</p>

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /Барилга бүтээц/
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ

2024 оны 01 сарын 12 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12-р хороо
3	Зураг төслийн байгууллага	"Ориентплюс" ХХК
4	Зургийн шифр	ЕГ Шифр:-ОР-05/2023
5	Хуудасны тоо	89
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Байгаль цаг уурын дараах нөхцөлд боловсруулсан үүнд: Гадна агаарын температур - 34,1оС Цасны ачаалал 50кг/м2 Салхины ачаалал 34кг/м2 Газар хөдлөлийн 7балл
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;	Аймгуудад баригдаж буй. Гал түймэр унтраах ангийн барилгад зөвхөн суурийн зурагт холболт хийж гүйцэтгэжээ. "Ленд тест" ХХК-ийн боловсруулсан архив №23/243 дугаартай, инженер геологийн судалгааны дүгнэлтээр суурь суух хөрс нь: Карбонь настай тунамал гарал үүсэлтэй хөх саарал ногоовтор өнгийн сул өгөршсөн элсэн чулуу /ИГЭ-1/ Хөрсний физик шинж чанарын үзүүлэлт: Эзлэхүүн жин $W=2,47г/см^3$ Өгөршөөгүй эслэн чулууны дундаж нягт 2,60 г/см ³ Өгөршлийн зэрэг $K_{wr}=0,95$ /Сулавтар өгөршсөн/ Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх бат бөх чанарын үзүүлэлт: Усаар ханасан үед $R_c=55,0-30,0$ МПа Байгалийн чийгтэй үед 85,0-50,0 МПа Элсээр чигжигдсэн хайрган хөрс нь улирлын хөдөлтийн бүсэд өвийлт үзүүлэхгүй. Улирлын хөдөлтийн норматив гүн - 3,59м болно.
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	

Д/д	Утга	Тайлбар
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдал, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	
Дүгнэлт бичсэн Эксперт № 2-19		Уг зургаар барилга угсралтын ажил гүйцэтгэж болно гэж дүгнэв.



2024 оны 01 сарын 12 өдөр

Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар.....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /Дулаан хангамж/
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ

2024 оны 01 сарын 10 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12-р хороо
3	Зураг төслийн байгууллага	"Хаспроект" ХХК
4	Зургийн шифр	ХП-07/2023
5	Хуудасны тоо	ДМ-5
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Халаалтын цахилгаан зуухны ажлын зураг төслийг боловсруулахдаа барилга архитектур, Увс аймгийн Баруун туруун суманд баригдах гал унтраах ангийн барилгын нэг маягийн зураг зэргийг үндэслэн гүйцэтгэсэн байна.
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байна.
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	Барилгын халаалтын систем PTE-60 маркийн 3 ширхэг цахилгаан зуухнаас хангахаар төлөвлөсөн байна. Халаалтын системийн дулааны ачаалал Q=70,95кВт Агаар сэлгэлтийн системийн дулааны ачаалал Q=35,50кВт хэрэгцээний халуун усны дулааны ачаалал Q=45,68кВт
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. Ерөнхий шаардлага /БНБД 12-03-04/, БНБД 12-03-06-ын шаардлага, БНБД12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн зааврыг тайлбар бичигт тусгах шаардлагатай.
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тайлбар бичигт тусгах
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	Инженерийн хангамжийн өөр хувилбар, харьцуулсан тооцоо байхгүй
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргаагүй
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг хавсралтаас үзэх
<p>Дүгнэлт бичсэн Эксперт № 3-17</p> <p>МОНГОЛ SERENBALJID Badarch CONSULTING ENGINEER 03 - 446</p> <p>Б.Цэрэнбалжид /...../</p> <p>2024 оны 01 сарын 10 өдөр</p>		

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ДУГААР АНГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ

2024 оны 01 сарын 10 өдөр


Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
